

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Г.НАРАНХҮҮГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг: Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт.

№	Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн тайлан				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт. 1 Төсвийн хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, төсвийн гүйцэтгэл , мэдээллийн ил тод байдлыг хангана.							
1.	Арга хэмжээ 1.1 Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих.	Төрийн 8-н байгууллагын албан хаагчдыг цалингийн нэгдсэн системд 100% холбох Цалин хөлсний зардалд бүрэн хяналт тавин ажиллана.	Төсвийн 8 байгууллагын 142 төрийн албан хаагчийн цалинг төрийн албаны цалингийн нэгдсэн системээр тооцон олгож , 2023 оноос гүйлгээ цахимаар хийж иргэдийн данс руу шууд илгээгдэх болсон. Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системийн үйл ажиллагаа,төлөвлөлт хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.	50%	Төсвийн 8 байгууллагын 150 төрийн албан хаагчийн цалинг төрийн албаны цалингийн нэгдсэн системээр тооцон олгож , 2023 оноос гүйлгээ цахимаар хийж иргэдийн данс руу шууд илгээгдэх болсон. Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системийн үйл ажиллагаа,төлөвлөлт хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.	2024.01.01-2024.12.31	100

2.	Арга хэмжээ 2.1 Төрийн болон орон нутгийн өмчит ААН байгууллагуудын төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллах	Төсвийн 8 байгууллага, төрийн сан, Баянтээг ХК, зэрэг нийт 13 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавина. Шилэн дансны мэдээллийг 100% байршуулна.	Төсвийн ил тод байдлыг хангах Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 5 төрлийн мэдээллийг 8 төсвийн байгууллага, 4 сан, 1 ХК –ны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын, орон нутгийн орлого, санхүүжилтийн мэдээг шилэн дансанд байршуулсан. Мөн байгууллагуудын дотоод хяналтын баг шилэн дансны мэдээллийн явцад хяналт шалгалт хийсэн.	50%	8 төсвийн байгууллага 4 сан 1 ХК –ны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын, орон нутгийн орлого, санхүүжилтийн 1-11 сарын мэдээг шилэн дансанд байршуулсан. Төсвийн ил тод байдлыг хангах Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 3 бүлэгт хамаарах мэдээллийг хуульд заасан хугацаанд чанартай үнэн зөв тавьж хэвшээд байна. 2024 оны 3 дугаар улирлын шилэн дансны мэдээллийг санхүү хяналт дотоод аудитын албан шалгалт хийхэд нийт 1232 мэдээлэл шилэн дансанд оруулахаас 58 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл мэдээлээгүй байна. Соёлын төв 1 мэдээлэл мэдээлээгүйг нөхөж байршуулсан. ЗДТГазар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 7,398.0 мян.төг мэдээлэл дутуу байршуулсныг нөхөж байршуулсан. Мөн байгууллагуудын дотоод хяналтын баг шилэн дансны мэдээллийн явцад хяналт шалгалт хийсэн.	2024.01.01-2024.12.31	100
----	---	---	---	-----	---	------------------------------	-----

3.	Арга хэмжээ 3.1 Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулах.	- Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа Хэтэрсэн зээлийн өр 2023.12.31 ны байдлаар 39167.68 мян.төг байна. Үүнээс шүүхийн байгууллагад шилжсэн 10 иргэний 20502.8 мян/төг зээлийн өр байна. Үлдсэн 16814.88 мян.төг зээлийг Шүүхийн байгууллагад шилжүүлж өрийн үлдэгдлийг 10% бууруулсан байна.	2023 онд шүүхийн байгууллагад шилжүүлсэн зээлдэгч байхгүй. Шүүхийн байгууллагад Шилжүүлж зээлийн өр төлбөрөөс нийт 2 хүний 1027.52 мян.төг зээлийг төлүүлж ажилласан..	51%	Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл оны эхэнд 233,743.9 мян.төг байсан. 12 сарын 01 ний байдлаар 75,865.6 мян.төг буюу 32.5 хувиар буурсан. 12 сарын 01 ний байдлаар шүүхийн байгууллагад шилжсэн 5 иргэний 11,897.9 мян.төг байна. 2024 онд нийт 5 зээлдэгчийн 8,604.9 мян.төг-ийн зээлийг төлүүлж ажилласан. Шүүхийн байгууллагад шилжүүлж өрийн үлдэгдлийг 41.9% бууруулсан байна. 2024 онд шинээр 2 зээлдэгчийн 6,839.4 төгрөгийн зээлийг шүүхийн байгууллагад шилжүүлж ажилласан.	2024.01.01-2024.12.31	100 %
4.	Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн,	Тендерт шалгарсан сумын ААНБ-ын тоо Орон нутгийн үйлдвэрлэгчдээс нийлүүлсэн бүтээгдэхүүний тоог 2023 оны суурь түвшнээс бууруулахгүй.	2023 онд шууд худалдан авах ажиллагааны аргаар 10 ажил хийгдсэн. Үүнээс 5 ажлыг сумын ААН, иргэд шалгарч уг ажлыг хийж гүйцэтгэсэн.	50%	2024-онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 38 төсөл арга хэмжээ хийхээр төлөвлөгдсөн. Суманд зарлагдсан 6 ажлыг суманд үйл ажиллагаа явуулдаг ААН-үүд болон сумын иргэд, 7 ажлыг ӨВ аймагт үйл ажиллагаа явуулдаг ААН, 8 ажлыг Улаанбаатар хотын ААН шалгарч ажил хэрэгжүүлж байна. 17 ажил гүйцэтгэгч шалгараагүй байна. Худалдан	2024.02.01-2024.12.31	100

	Худалдан авах үйл ажиллагааны тендер шалгаруулалтыг цахимаар явуулна.				авах үйл ажиллагааны хуулийн дагуу тендер шалгаруулалтыг 100% цахимаар явуулсан. Шууд худалдан авах ажиллагааны аргаар 13 ажил, харьцуулалтын аргаар 8 ажил тус тус зарлагдсан байна.		
5.	Арга хэмжээ 1.5. Худалдан авах үйл ажиллагааны тендер Шалгаруулалтыг 100% цахимаар явуулна.	-Тендер шалгаруулалтыг 100 цахимаар явуулсан байна. - 2021 оны 05 сарын 5-ны өдрийн 124 дугаар тогтоолоор цахимд тавих тендерийн доод үнийг 20,0 сая болгосонтой холбоотойгоор шууд худалдан авах ажил цахимд тавигдахгүй.	Суманд зарлагдсан 16 тендерээс 3 тендер 100 хувь цахимаар зарлагдан "tender.gov.mn" цахим сайтад тендер оролцогчийн мэдээлэл болон үр дүнг тавьсан. 15 төсөл арга хэмжээ Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 124 дугаар тогтоолоор цахимд тавих тендерийн доод үнийг 20,0 сая болгосонтой холбоотойгоор шууд худалдан авах аргаар зарлагдсан.	50%	Суманд зарлагдсан 21 тендэрээс 8 тендер 100 хувь цахимаар зарлагдан "tender.gov.mn" цахим сайтад тендер оролцогчийн мэдээлэл болон үр дүнг тавьсан. 13 төсөл арга хэмжээ Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 124 дугаар тогтоолоор цахимд тавих тендерийн доод үнийг 20,0 сая болгосонтой холбоотойгоор шууд худалдан авах аргаар уламжлалаар зарлагдсан.	2024.02.01-2024.12.31	100
6.	Арга хэмжээ 1.6. Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн	Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гүйцэтгэгчтэй ажил гэрээ гүйцэтгэх	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 7 ажилд сумын Засаг даргын захирамжаар иргэний төлөөлөл оролцуулсан 5	52%	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 11 ажилд сумын Засаг даргын захирамжаар иргэний төлөөлөл орцуулсан 5 хүний бүрэлдхүүнтэй	2024.02.01-2024.12.31	100

	явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ.	байгуулан, тухайн ажлыг хийж байгаа хугацаанд нь хууль журмын дагуу хяналтын ажлын хэсэг байгуулан нийт худалдан авах ажилд 100% хяналт тавина.	хүний бүрэлдэхүүнтэй хяналтын ажлын хэсэг ажилласан.		хяналтын ажлын хэсэг ажилласан.		
7.	Арга хэмжээ 1.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажлын үе шатны хяналтыг сайжруулан, ил тод байдлыг бүрэн хангаж, "шилэн данс"-ны Мэдээллийг тогтмол шинэчлэх, худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд дуусгах.	Худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд дуусгасан байдал болон мэдээллийг тухай бүр 100% байршуулсан байх -Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдлын тоо 0 байх	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2023 онд зарлагдах 18 ажлын тендерийн үнэлгээний хороо, ажлын хэсгийг 2023 оны 04 сарын 01-нээс өмнө Засаг даргын захирамжаар байгуулагдсан. "шилэн данс"-нд тогтмол мэдээлж байна.	52%	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг 2023 оны оны 4 сард иргэдээс авч Багийн иргэдийн нийтийн хурлаар саналуудыг эрэмбэлж сумын ажлын хэсэгт хүргүүлэн, Сумын ажлын хэсэг багуудаас ирсэн саналыг сумын түвшинд эрэмбэлэн Сумын Засаг даргын зөвлөлд хүргүүлэх, тухайн жилийн төсөвт багтаан эхний байрт эрэмбэлэгдсэн ажлуудыг хийхээр сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулан уг ажлын төлөвлөгөөг 01 сарын 10-ны дотор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "tender.gov.mn" сайтад шивж баталгаажуулан төлөвлөгөөний дагуу зарцуулж байна. ОНХС-ийн 21 төсөл арга хэмжээ 822,214.1 мян,төг	2024.02.01-2024.12.31	100

					урьд онд хийгдээгүй үлдэгдэлт 4 төсөл арга хэмжээнд 57,724,2 мян.төг, Малын албан татварын санхүүжилтээр 6 төсөл арга хэмжээнд 143,000.0 мян.төг урьд онд хийгдээгүй 7 төсөл арга хэмжээ 160,441.2 мян.төг нийт 38 төсөл арга хэмжээнд 1,183,379.5 мян.төг зарцуулахаар төлөвлөгдсөн. Орон нутгийн хөгжлийн сан 2024.12.01 ний өдрий байдлаар санхүүжилт 653,178.9 мян.төг, Малын албан татвар 105,551.01 мян.төг урьд оны харилцахын үлдэгдэл 83,370.1 мян.төг нийт 842,100.01 мян.төг-ийн санхүүжилтээр 14 төсөл арга хэмжээ 100 хувийн гүйцэтгэлтэй, 2 төсөл арга хэмжээ 87.5 хувийн гүйцэтгэлтэй, 7 төсөл арга хэмжээ 30-87.5 хувийн гүйцэтгэлтэй нийт 558,630.6 мян.төг зарцуулан харилцахын үлдэгдэл ОНХС үлдэгдэл 197,976.91 мян.төг, МАА татварын үлдэгдэл 85,492.5 мян.төг байна.		
8.	Арга хэмжээ 1.8. Төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг	- Монгол Улсын 2023 оны төсөвтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын	Төрийн хэмнэлтийн тухай” хууль зэргийг мөрдөн ажиллаж байна Төсвийг анхан шатны	50%	Засгийн газрын 2021 оны 93 тогтоол “Орон нутаг болон тусгай зориулалтын	2024.01.01-2024.12.31	100

	сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан төсвийн шууд захирагч, төрийн албан хаагчтай хариуцлага тооцох, ил тод шуурхай механизмыг бий болгон хэрэгжүүлнэ	шийдвэрийг тухай бүр мөрдөж ажилласан эсэх - Төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх. - Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн, үнэн зөв, хугацаанд нь оруулах. - Хуулийн хугацаандаа мэдээгээ мэдүүлээгүй төсөвт байгууллагын дарга нягтлан бодогч нарт хариуцлага тооцох.	баримтад тулгуурлан, Батлагдсан төсөвт багтаан гүйлгээг хийж байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулаагүй хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулж байна. Төсвийн орлого, төсвийн гүйцэтгэлийн мэдээг Шилэн данс болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан төсвийг ил тод нээлттэй болгож байна.		шилжүүлэгийн санхүүгийн дэмжлэгийг бууруулан тооцох 2022 оны 04 сарын 22-ны өдрийн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль зэргийг мөрдөн ажиллаж байна Төсвийг анхан шатны баримтанд тулгуурлан, тухайн батлагдсан төсөвт багтаан гүйлгээг хийж, хянан батлаж байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулаагүй хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулж байна. Мөн сар бүрийн 05-ны дотор багтаан төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагууд өгч ажиллаж байна. Хуулийн хугацаандаа мэдээгээ өгсөн төсөвт байгууллагын гүйлгээг хянан батлах зарчимаар ажиллаж байна. Төсвийн орлого, төсвийн гүйцэтгэлийн мэдээг Шилэн данс болон байгууллагын мэдээлэлийн самбарт байршуулан төсвийг ил тод нээлттэй болгож байна.		
9.	Арга хэмжээ 1.9. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг	2024 онд шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтыг данс Хэмжээгээр бүртгэлд 100% авах Баланст байгаа	Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан байгууллага бүрд "өмч хамгаалах байнгын зөвлөл",	50%	Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан байгууллага бүрт "өмч хамгаалах байнгын зөвлөл", дотоод хяналтын баг	2024.01.01-2024.12.31	100

	сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.	хөрөнгийн бүртгэл, тайлан мэдээг 100% ил тод болгоно.	дотоод хяналтын баг төлөвлөгөөний дагуу өмч хөрөнгөд хяналт тавин бүрэн бүтэн байдлыг ханган, холбогдох албан хаагчидтай хамтран ажиллаж байна.		төлөвлөгөөний дагуу өмч хөрөнгөд хяналт тавин бүрэн бүтэн байдлыг ханган хагас жилийн, жилийн эцсийн хөрөнгө тооллогыг хийн ажиллаж байна.		
10.	Арга хэмжээ 1.10. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь өмч хөрөнгийн бүртгэл тооллого, ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар тухайн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.	- Төлөвлөгөө боловсруулах - ЗДТГ-ын өмч хөрөнгө болон тооллогын ажилд хяналт тавих -Төлөвлөгөөний хэрэгжилт	100%	100%	Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2024 оны эхний улиралд хуралдан өмч хөрөнгийн бүртгэл тооллого, ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар тухайн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, 2024 оны хагас жилийн хөрөнгө тооллогыг хийн шинээр худалдан авсан болон актлах шаардалагтай хөрөнгийн жагсаалтыг гарган зөвлөмжийг хүргүүлж ажилласан. 2024 оны хагас жилийн байдлаар ЗДТГ-д 4,071,080.5 анхны өртөг бүхий 584 нэр төрлийн хөрөнгө тоологдсон байна. Үүнээс 125,905.01 анхны өртөг бүхий 82 нэр төрлийн хөрөнгийг актлах зөвлөмж хүргүүлсэн.	2024.01.01-2024.12.31	100

11.	Дэд хэмжээ 1.10.1 Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны төлөвлөгөөг боловсруулах	-Төлөвлөгөө боловсруулах	30%	30%	2024 оны төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан . ?	2024.01.01-2024.06.30	100
12.	Дэд хэмжээ 1.10.2 ЗДТГ-ын өмч хөрөнгө болон тооллогын ажилд хяналт тавих.	-Тооллогын ажлыг 100% гүйцэтгэх	40%	40%	Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого 2024 оны 06 болон 12 саруудад тус тус хийгдэнэ. 2024 оны 6 сард хагас жилийн хөрөнгө тооллогыг хийсэн ба жилийн эцсийн хөрөнгө тооллого хийгдэж байна.	2024.01.01-2024.12.31	100
13.	Дэд хэмжээ 1.10.3 Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт	Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100% биелсэн байна.	30	30%	Өмч хамгаалах байнгын зөвлөл 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100% биелсэн байна.	2024.01.01-2024.12.31	100
14.	Арга хэмжээ 1.11. Тухайн жилийн төсвийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн	Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь	89.64%	50%	2024 оны төсвийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу суманд төвлөрүүлэх орлогыг нэр, төрөл бүрээр төлөвлөж төвлөрүүлэн ажиллаж байна. Тухайн	2024.01.01-2024.12.31	90

	Хурлаар батлуулж, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу суманд төвлөрүүлэх орлогыг нэр, төрөл бүрээр төлөвлөж төвлөрүүлэх.				жилийн татварын орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 777,302.9 мян.төг төлөвлөгдсөн бол гүйцэтгэл нь 98.2% буюу 762,942.2 төгрөгийн биелэлттэй байна.		
15.	Дэд хэмжээ 1.11.1 Татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх.	Татварын орлого 659909,2 мян.төг	2023 оны жилийн байдлаар татварын орлогын төлөвлөгөө 425350.9 мян.төг гүйцэтгэл 696727.8 мян.төг биелэлтийн хувь 100	37.5%	2024 оны татварын орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 692,850.9 төгрөг төлөвлөгдсөн бол гүйцэтгэл нь 2024 оны 11 сарын 30 ний байдлаар 97% буюу 672,562.1 төгрөгийн биелэлттэй байна.	2024.01. 01- 2024.12. 31	100
16.	Дэд хэмжээ 1.11.2 Татварын бус орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх.	Татварын бус орлого 70915,8 мян.төг	Татварын бус орлогын төлөвлөгөө 60720,3 мян.төг гүйцэтгэл 69158,3 мян.төг биелэлтийн хувь 100	4%	Татварын бус орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 84,452 мян.төг гүйцэтгэл 2024 оны 11 сарын 31 ний байдлаар 90,380.1 мян.төг биелэлтийн хувь 107%	2024.01. 01- 2024.12. 31	100
17.	Дэд хэмжээ 1.11.3 Тухайн төсвийн байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл	ЗДТГ -ын орлогын төлөвлөгөө 6000,0 мян.төг	Сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогын төлөвлөгөө 6000,0 мян.төг гүйцэтгэл 4995,5 мян.төг биелэлт 83,2 хувь байна	0.5%	Сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 9,040.0 мян.төг гүйцэтгэл 9,161.0 мян.төг биелэлт 101 хувь байна	2024.01. 01- 2024.12. 31	100

	ажиллагаанд харшлахгүйгээр орлогыг төлөвлөж, зарцуулах						
18.	Дэд хэмжээ 1.11.4 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг сайтар ханган ажиллах.	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 143,000.00 мян.төг	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 152,674.00 мян.төг гүйцэтгэл 52,195.00 мян.төг биелэлт 36,5 хувь байна.	8%	Малын тоо толгойн албан татварын орлогын урд оны авлага 197,321.6 мян.төг, 2024 оны төлөвлөгөө 143,000.00 мян.төг нийт 340,321.6 байна. гүйцэтгэл 105,551.01 мян.төг биелэлт 31.0 хувь байна.	2024.01. 01- 2024.12. 31	70

Хоёр: Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт.

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн хуулийн богино хугацааны сургалтад хамрагдах тухай заасан дунд	Суралцсан кредит цаг	0%	0%	Албан хаагчаас шалтгаалаагүй	2024.08.01-2024.12.31	-
2.	Арга хэмжээ 2. Монгол шатны сургалтад хамрагдах бичгийн анхан олгох	Суралцсан кредит цаг	0%	50%	Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтад 4-6 саруудад 7 хоногийн 4 дахь өдөр бүр хамрагдсан.	2024.01.01-2024.12.31	100
3.	Арга хэмжээ 2. Төрийн өмчийн ажил, тухай суурь болон орон нутгын бараа, авах хуулийг хэрэгжүүлэх мэдлэг олгох сургалт	Суралцсан кредит цаг	0%	100%	Сургалтанд хамрагдах хүний тоо бүрдсэн тул хамрагдаагүй. ОНХС-ийн гүйлгээний 2-р гарын үсгийн баталгаа хариуцдаг тул хамрагдах шаардлагагүй.	2024.01.01-2024.12.31	-

ТАЙЛАН ГАРГАСАН:
Төсвийн ерөнхий нягтлан бодогч
/албан тушаал/

Г.Наранхүү /  /
/нэр, гарын үсэг/

2024.12.05
/огноо/

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Г.НАРАНХҮҮГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

НЭГ. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАР”							
1.	Нэмэлт, өөрчлөлт орсон хэмжээ 1.1.1 Аймаг орон нутагт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэнийг албан татвар төлөгчийг бүртгэх журмын дагуу бүртгэж, тэдгээрийн борлуулалтын орлогыг цахим баримтын систем (И-баримт)-д бүртгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.	- Холбогдох журмын дагуу бүртгэсэн байдал - Цахим баримтын системийн ашиглалт	Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, аж ахуйн нэгжүүд тэдгээрийн борлуулалтын орлогыг цахим системд бүртгэсэн байна.	50%	Шинээр байгуулагдаж байгаа болон орон нутагт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй 10 аж ахуйн нэгжүүдэд борлуулалтын орлогыг цахим баримтын систем (И-баримт)-д бүртгэсэн. Тухайн аж ахуй нэгжүүд нь иргэдэд төлбөрийн баримт тогтмол олгож ажиллахад нь сар бүр хяналт шалгалт тавьж ажиллаж байна.	2024.01.01 – 2024.12.31	100%

2.	Нэмэлт, өөрчлөлт орсон хэмжээ 1.1.2 НӨАТ-ын буцаан олголтын урамшууллаас хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн албан татварын өртэй татвар төлөгчдийг өрөө суутган тооцуулах хүсэлт гаргах ажиллагааг идэвхжүүлэх, сургалт сурталчилгааг Татварын хэлтэстэй хамтран зохион байгуулах	- Иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааг хийж ажиллах - Хүсэлт гаргасан татвар төлөгчийн тоо	НӨАТ-ын буцаан олголтоос татварын өр төлбөрөө суутган тооцуулах татвар төлөгчийн тоо нэмэгдэж, татварын өрийн хэмжээ буурсан байна.	50%	НӨАТ-ын буцаан олголтын урамшууллаас хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн албан татварын өртэй татвар төлөгчдийг өрөө суутган тооцуулах хүсэлт гаргах ажиллагааг идэвхжүүлэх, сургалт сурталчилгааг Татварын хэлтэстэй хамтран цахимаар болон биечлэн явуулж байна. 2024 оны татварын орлогын төлөвлөгөө 11 сарын байдлаар 692,850.9 төгрөг төлөвлөгдсөн бол гүйцэтгэл нь 2024 оны 11 сарын 30 ний байдлаар 97% буюу 672,562.1 төгрөгийн биелэлттэй байна.	2024.01.01 – 2024.12.31	100%
3.	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 1.1.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, зах, худалдааны төвүүдэд урамшууллын “И-баримт” системийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл, татварын бааз суурийг нэмэгдүүлэх ажлыг хүрээнд “И-баримт” хэвлэж өгөх боломжгүй алслагдсан	- Иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааг хийж ажиллах - Цахим баримтын системийн ашиглалт	Биелэлтийг бүрэн хангахад хуулиар олгосон эрх, үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажилласан байна.	50%	Шинээр байгуулагдаж байгаа болон орон нутагт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд урамшууллын “И-баримт” системийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн системийн ашиглалтын талаар сургалт, сурталчилгааг хийж ажиллаж байна. Биелэлтийг бүрэн хангахад хуулиар олгосон эрх, үүргийнхээ хүрээнд сар	2024.01.01 – 2024.12.31	100%

	бүс нутаг, зах худалдааны төвд "ӨЕГ" код уншуулан И-баримт олгох ажлыг эхлүүлэх, цахим баримт хэвлэж байгаа эсэхэд хяналт тавих				бүр хяналт тавьж ажиллаж байна. "И-баримт" хэвлэж өгөх боломжгүй алслагдсан бүс нутаг, зах худалдааны төв байхгүй.		
1.	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 1.1.4 Орон нутгийн харьяалалтай аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авалт, баталгаажуулалтын түвшинг 100 хувиас доошгүй хувьд хүргэж, тайлан хүлээн авалтын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх	Тухайн орон нутгийн харьяалалтай 37 аж ахуйн нэгж байгууллага а	60%	100%	Орон нутгийн харьяалалтай 37 аж ахуйн нэгж байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авалт, баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлж байгууллага бүрд хуулийн хугацаа болон торгуулийн арга хэмжээний тухай сануулан, тайлаг гаргахтай холбоотой асуудлуудад заавар, зөвлөмж өгч ажиллаж байна. 2023 онд санхүүгийн тайлангаа өгөөгүй үйл ажиллагаа нь зогссон 15 аж ахуйн нэгжийн судалгааг гарган аймгийн төрийн санд хүргүүлсэн.	2024.01.01 – 2024.12.31	100%
2.	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 1.1.5 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Журам батлах тухай" 19/04 дүгээр тогтоолын дагуу төсвийн хөрөнгө	- Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд - Олон нийтийг	4-с доошгүй удаа	0%	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Журам батлах тухай" 19/04 дүгээр тогтоолын дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн суманд хийгдэж буй	2024.01.01 – 2024.12.31	100%

	оруулалтаар тухайн суманд хийгдэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олон нийтийг төлөөлөх хяналтын зөвлөлийг ажиллуулах.	төлөөлөх хяналт хийсэн тоо			төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олон нийтийн төлөөллөөс 11 хүн сумын Засаг даргын захирамжаар оролцуулан хяналт тавьж ажилласан.		
3.	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 1.1.6 Сангийн сайдын баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажилалгааны журам"-ын хэрэгжилтийг хангаж, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /https://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д мэдээллийг цаг тухайд нь байршуулах.	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хувиар (70 хувиас дээш-25 хувь урамшуулал, 90 хувиас дээш-30 урамшуулал	Аймгийн 2023 оны үнэлгээ 77 хувь	100%	"Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажилалгааны журам"-ын хэрэгжилтийг хангаж, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлага мэдээллийн систем /https://tusuv-oronnutag.mof.gov.mn/-д мэдээллийг цаг тухайд нь байршуулсан. 2023 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хувиар 70 хувиас дээш буюу 26 хувиар урамшуулал тооцогдсон байна.	2024.01.01 – 2024.12.31	70%
	Нэмэлт, өөрчлөлт орсон хэмжээ 1.1.7 Засгийн газрын 2018 оны "Орон нутгийн хөгжлийн	Хөгжлийн индексийн мэдээллийг шинэчилсэн эсэх	Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд сумын хөгжлийн	100%	Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим систем www.lidi.med.gov.mn –д сумын хөгжлийн индексийн	2024.01.01 – 2024.12.31	100%

	индекс тооцох аргачлал” батлах тухай 20 дугаар тогтоолын дагуу сумдын хөгжлийн индексийн мэдээллийг 2023 оны байдлаар шинэчлэн www.idi.med.gov.mn цахим системд хугацаанд нь байршуулах		индексийн мэдээллийг тухай бүр шинэчлэн хугацаанд байршуулсан байна.		мэдээллийг шинэчлэн хугацаанд нь байршуулсан.		
--	---	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1.						
2.	Арга хэмжээ 2.						
3.							

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төсвийн ерөнхий нягтлан бодогч
(Албан тушаал)

Г.Наранхүү /  /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)